

ТАНИЛЦУУЛГА

“Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын хамтарсан тушаалын
төсөл боловсруулсан тухай

2021 оны 02 дугаар сарын 25

Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050”, “Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын санд хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулж Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Маягт, журам батлах тухай” 246/А/245 дугаар хамтарсан тушаалаар батлан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл” авах хүсэлт гаргасан зээлдэгч (ажил олгогч)-д нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг гаргаж өгөх шаардлагатай байна.

Мөн Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Маягт, журам батлах тухай” 246/А/245 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх журам-ын 2.26.9-д заасан “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код”-ын хүснэгтийг өөрчлөх, улмаар 4 төрлийн даатгуулагчийн кодыг нэмж бүртгэх шаардлагатай байна. Учир нь нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомжид нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх тухай бүрт хэрэгжилтийг хангаж ажиллахад уг тушаалд өөрчлөлт оруулах зэргээр хүндрэл учирахаар байна. Дараах даатгуулагчийн төрөл, кодыг нэмэхээр тушаалын төсөлд тусгав. Үүнд:

- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дурын даатгуулагч эх;
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа сайн дурын даатгуулагч эх;
- ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тахир дутуугийн тэтгэвэр авагч;
- Цэргийн алба хаасан хугацааг иргэний байгууллагад ажилласнаар тооцон улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлээ төлүүлсэн иргэн.

Ийнхүү “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт”-ын маягт /Б-НД-12.1/, маягт хөтлөх журмын заалтыг шинээр, даатгуулагчийн төрөл, кодын хүснэгтийг шинэчлэн батлуулахаар Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалын төслийг боловсрууллаа.

Энэхүү хамтарсан тушаалын төслийг баталснаар ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэл сайжирч, нийгмийн даатгалын үйлчилгээ чирэгдэлгүй, шуурхай, ойлгомжтой болж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл бүрдэх ба ямар нэг нэмэлт зардал гарахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ